

Ипотекийн зээлийн тайлан

2014 оны 7 дугаар сар


Банкууд 2014 оны 7 дугаар сард нийт 1440 зээлдэгчид 77.4 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноор банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл 2492.1¹ тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 59756-т хүрчээ.

Тайлант сарын эцэст банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд өмнөх сартай харьцуулахад 40.6 нэгж хувиар, оны эхнээс 33.6 нэгж хувиар буурсан ч өмнөх оны мөн үеэс 25.4 нэгж хувиар нэмэгдсэн байна.



Банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” (ОСИСТТБХ)-ийн хэрэгжилттэй холбоотойгоор 2013 оноос эхлэн эрс нэмэгдсэн байна.


Ипотекийн зээлийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь



*2014 оны 7-р сарын ипотекийн зээлийн үлдэгдлийг 2013 оны 12-р сарын нэрлэсэн ДНБ-д харьцуулсан.

Тайлант сарын эцэст банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 69.3 хувь буюу 1728.2 тэрбум төгрөгийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл (8 хувийн хүүтэй зээл болон 8 хувийн хүүтэй зээлд шилжүүлсэн зээл), 27.8 хувь буюу 692.1 тэрбум төгрөгийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 2.9 хувь буюу 71.8 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэл, эх үүсвэрээр



¹ МИК-т шилжүүлсэн зээлийн дүн орсноор.

2014 оны 7 дугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 97.7 хувь нь төгрөгийн зээл, 2.3 хувь нь гадаад валютын зээл байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь харьцангуй тогтвортой байгаа бөгөөд 2014 оны 7 дугаар сарын байдлаар 0.4 хувь байна.



Ипотекийн зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх сараас 0.6 хувиар өсч 1.2 хувь хүрсэн.

Тайлант сард олгосон зээл

Тухайн сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 21.4 хувиар, өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 53.8 хувиар буурсан байна.



Тайлант сард шинээр олгосон зээлийн 67.5 хувь буюу 52.2 тэрбум төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл, 32.4 хувь буюу 25.1 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна.

Нэг зээлдэгчид ногдох олгосон зээлийн хэмжээ 2010 оны дунд үеэс өссөөр 2014 оны 7 дугаар сарын байдлаар 53.7 сая төгрөгт хүрчээ.



Тухайн сард 26.6 тэрбум төгрөгийн ипотекийн зээл төлөгдсөн нь өмнөх сараас 11.9 хувиар өссөн ч өмнөх оны мөн үеэс 21.5 хувиар буурсан байна.



Зээлдэгчдийн тоо

Тайлант сард нийт 1440 иргэн шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 878 иргэн “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 561 иргэн банкны өөрийн эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.



2014 оны 7 дугаар сарын байдлаар нийт 59756 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 39507 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 18161 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 2088 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.



Зээлийн хугацаа

Тайлант сард банкууд 0.5-20 жилийн хугацаатай зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 15.7 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 2014 оны 7 дугаар сарын байдлаар 15.0 жил байна.

Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 48.8 хувь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон. Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 42.0 хувь нь 16-20 жил, 28.1 хувь нь 11-15 жил, 16.4 хувь нь 6-10 жил, 3.7 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.



Зээлийн хүү

Банкуудын 2014 оны 7 дугаар сард олгосон ипотекийн зээлийн хамгийн өндөр хүү нь жилийн 26.4 хувь, хамгийн бага нь 2.4 хувь байсан бөгөөд тухай сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 10.7 хувь байв. “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад

жигнэсэн дундаж хүү 5.9 нэгж хувиар буурсан байна.



Банкуудын өөрийн эх үүсвэрээр төгрөгөөр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 16.6 хувь, валютаар олгосон зээлийнх 10.5 хувь байв.

Хавсралт 1. Банкуудын ипотекийн зээлийн тайлан

Он	Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.)	Үүнээс:	Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (сараар)	Тухайн сард олгосон зээлийн ЖДХҮҮ, жилээр (%)	Нийт зээлдэгч (тоогоор)	
			ОСИСТГБ хөтөлбөрийн зээл				
2008	12	217,977.5		100.7	19.8	16,522	
2009	12	226,040.6		103.4	18.7	16,784	
2010	12	333,776.6		115.0	16.0	19,700	
2011	12	669,662.8		154.3	14.8	26,869	
2012	12	845,204.4		155.5	15.3	29,887	
2013	1	856,633.6		149.1	17.0	29,683	
	2	873,666.4		156.1	16.8	29,946	
	3	903,557.5		158.6	15.7	30,419	
	4	944,516.8		155.4	15.8	31,412	
	5	986,182.2		147.8	16.6	32,247	
	6	1,032,156.7		276,328.4	168.3	12.9	33,028
	7	1,273,003.6		553,346.9	202.4	9.2	37,751
	8	1,461,753.4	781,483.2	207.6	8.9	40,596	
	9	1,611,383.8	943,976.7	206.0	9.1	42,968	
	10	1,750,781.6	1,076,924.5	193.9	9.6	45,138	
	11	1,834,042.7	1,155,409.2	192.8	9.7	46,482	
	12	1,938,945.3	1,248,633.8	192.8	9.9	48,320	
2014	1	2,021,424.9	1,324,898.9	194.4	9.8	49,731	
	2	2,121,802.6	1,382,084.1	193.2	9.9	53,611	
	3	2,193,368.6	1,451,938.1	190.7	9.9	54,787	
	4	2,280,503.5	1,538,506.8	192.1	9.8	56,137	
	5	2,365,349.5	1,618,127.2	189.3	10.0	57,579	
	6	2,440,007.1	1,684,583.9	182.3	10.5	58,793	
	7	2,492,105.2	1,728,222.8	187.9	10.7	59,756	

Хавсралт 2. Орон нутгийн банкуудын ипотекийн зээлийн тайлан

2014 оны 6 дугаар сарын байдлаар

Аймгууд	Ипотекийн зээлийн		Үүнээс ОСИСТБХ-ийн зээл		Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХугацаа (сар)	Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХүү (жилээр)	Нийт зээлдэгчдийн тоо
	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь			
1 Улаанбаатар	1,870,789.8	76.7%	1,246,684.7	74.0%	182.3	10.7	39229
2 Дархан-Уул	94,343.1	3.9%	78,772.4	4.7%	196.6	8.6	2983
3 Орхон	85,165.0	3.5%	71,109.1	4.2%	184.7	9.6	2457
4 Дорноговь	51,466.2	2.1%	40,195.2	2.4%	194.8	8.0	1603
5 Сэлэнгэ	34,833.3	1.4%	25,979.2	1.5%	185.7	10.0	1274
6 Дорнод	31,566.5	1.3%	27,375.3	1.6%	185.2	8.7	1112
7 Өвөрхангай	30,812.0	1.3%	21,525.0	1.3%	169.9	12.1	1174
8 Увс	30,233.0	1.2%	20,987.1	1.2%	152.1	12.7	1091
9 Баянхонгор	27,733.4	1.1%	24,182.8	1.4%	183.3	9.3	835
10 Өмнөговь	25,809.7	1.1%	17,273.8	1.0%	152.5	11.8	757
11 Ховд	23,378.3	1.0%	19,619.0	1.2%	219.4	8.3	894
12 Баян-Өлгий	17,200.9	0.7%	8,461.9	0.5%	118.5	14.9	904
13 Сүхбаатар	15,971.5	0.7%	10,710.8	0.6%	168.1	12.2	625
14 Архангай	15,512.1	0.6%	11,975.3	0.7%	110.5	11.3	513
15 Говь-Алтай	14,291.9	0.6%	11,377.4	0.7%	208.4	8.8	504
16 Хөвсгөл	12,996.9	0.5%	6,306.4	0.4%	131.4	16.7	568
17 Завхан	10,500.5	0.4%	7,241.9	0.4%	160.4	8.0	498
18 Дундговь	10,025.0	0.4%	7,801.3	0.5%	211.8	8.0	336
19 Төв ХХХ	9,886.4	0.4%	7,113.1	0.4%	174.0	11.0	360
20 Говьсүмбэр	9,554.5	0.4%	8,674.5	0.5%	219.3	8.0	364
21 Булган	9,464.7	0.4%	4,926.2	0.3%	156.3	7.3	381
22 Хэнтий	8,472.5	0.3%	6,291.3	0.4%	136.8	12.3	331
Нийт	2,440,007.1	100%	1,684,583.9	100%	182.3	10.5	58793

2014 оны 6 дугаар сарын байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 76.7 хувийг Улаанбаатар хотод, 23.3 хувийг хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээл бүрдүүлжээ. Хөдөө орон нутаг дахь ипотекийн зээлийн үлдэгдлийн 16.6 хувь буюу 94.3 тэмбум төгрөг Дархан-Уул аймагт, 15.0 хувь буюу 85.2 тэмбум төгрөг Орхон аймагт, 9.0 хувь буюу 51.5 тэмбум төгрөг Дорноговь аймагт ногдож байна.